

## ӨГҮҮЛЭЛ

**Орчин цагийн олон улсын харилцаа ба  
“Гибрид дайн”-ы талаар хийсэн судалгаа, үнэлэлт дүгнэлт****Пүрэвдоржийн Мягмардорж** 

Доктор (Ph.D)

Хүмүүнлэгийн ухааны их сургууль,

Олон улсын харилцаа, нийгэм судлалын сургууль, Улаанбаатар, Монгол Улс  
[myagmardorj@humanities.mn](mailto:myagmardorj@humanities.mn)

**Хураангуй:** Өнөөгийн дэлхийн улс төрийн бодлого дахь хүчний төвийн шилжилт, их гүрнүүдийн геополитикийн сөргөлдөөн зэргээс улбаалан олон улсын харилцааны нөхцөл байдал тун тогтворгүй байна. Ийм нөхцөлд Монгол Улсын аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болох гадаад хүчин зүйлсийн эрсдэлийн судалгаа, тэр дундаа орчин цагийн олон улсын харилцаан дахь “гибрид дайн” хэмээх ойлголт, “гибрид дайн”-ы мөн чанар, хэлбэр ба арга тактикийн талаар үнэлгээ дүгнэлт хийх шаардлагатай гэж үзсэн учир энэхүү судалгааг хийсэн болно. 2014 оны хавар эхэлсэн Крымын асуудлын дараачаар барууны судлаачдын дунд ОХУ-ын нөлөөний хүрээгээ тэлэх бодлого, ялангуяа Украины талаар явуулж буй бодлогыг судлахдаа “гибрид дайн” хэмээх нэр томъёог нийтлэг хэрэглэж эхэлсэн. Украиныг дотроос нь хагалган бутаргах, салан тусгаарлагчдын үйл ажиллагааг дэмжих зорилгоор явуулж буй “уламжлалт” болон “уламжлалт бус” дайны аргыг хослуулан хэрэгжүүлж буй үйл ажиллагааг “гибрид дайн”-ы хүрээнд судлах болсон. Гэхдээ энэхүү “гибрид дайн” нь тухайн сөргөлдөгч улсуудын цэрэг стратегийн хүч, эдийн засгийн чадавх, улс төрийн нөлөө, газарзүйн байршил зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан олон янзын загвартай байхаас гадна маш олон хэлбэрээр илэрдэг болох нь судалгаанаас харагдаж байна.

**Түлхүүр үгс:** Герасимовын номлол, гибрид дайн, гибрид дайны арга хэлбэрүүд



## Удиртгал

Хүйтэн дайны дараа тогтсон “олон улсын харилцааны шинэ дэг журам” нь саяхныг хүртэл АНУ-ын цэрэг-улс төр, эдийн засаг, соёлын давамгайллаар өрнөж байв. Тэгвэл олон улсын харилцааны системд зохих ёсны байр сууриа хадгалж үлдэх, улмаар хүч нөлөөгөө нэмэгдүүлэх, цаашлаад системийн хүчний төв болох зорилго бүхий БНХАУ, ОХУ зэрэг улс гүрнүүд олон улсын харилцааны системийг орчин, бүтэц, агуулга, хэлбэрийн хувьд өөрчлөхөөр тус тусын бодлого, стратегийг боловсруулан хэрэгжүүлж эхлээд байгаа нь өнөөгийн олон улсын харилцааны судлаачдын хувьд анхаарал татсан сэдэв болжээ. Нөгөөтэйгүүр 21-р зуун гарсаар даяаршлаас улбаатайгаар олон улсын харилцаа нь олон түвшний, янз бүрийн оролцогчдын хоорондын төрөл бүрийн хэлбэрийн харилцааны цогц систем болон өргөжин тэлж байна. Үүнийг дагаад олон улсын харилцааны оролцогчдын “харилцан хамаарал”<sup>1</sup> буюу эдийн засгийн хувьд нэг нь нөгөөгөөсөө хамааралтай болсон явдал улам гүнзгийрсэн тухай ч судлаачид бичиж байна.

Олон улсын харилцааны эдгээр бодит нөхцөл байдлаас шалтгаалан системд нөлөөгөө хадгалж үлдэхийг зорьж буй улс гүрэн болон дэлхийн бодлогыг шинээр тодорхойлохыг зорьж буй улс гүрнүүд уламжлалт хүчний

элементүүдийг ашиглан “сонгодог дайн”-ы арга хэрэгслийг сонгохоос илүүтэй “уламжлалт бус” буюу “гибрид дайн”<sup>2</sup>-ы арга хэрэгслийг сонгон эрх мэдэл, нөлөөнийхөө хүрээг тэлэх болсон талаар олон судлаачид бичих болжээ. Ялангуяа ОХУ-ын Зэвсэгт Хүчний Жанжин Штабын дарга В.В.Герасимовын 2013 оны 02 дугаар сарын 26-нд Оросын долоо хоног тутмын сонин болох “Военно-Промышленный Курьер”-т хэвлүүлсэн “Зэвсэгт хүчнийг ашиглах арга хэлбэрийг хөгжүүлэх үндсэн чиг хандлага, тэдгээрийг сайжруулах цэргийн шинжлэх ухааны тулгамдсан зорилтууд”<sup>3</sup> сэдэвт өгүүллийн дараачаар барууны судлаачид энэхүү сэдвийг ихэд анхааран судлах болсон.

2012 оноос ОХУ-ын БХЯ-ны орлогч сайд бөгөөд Зэвсэгт Хүчний Жанжин Штабын даргаар ажиллаж буй В.В.Герасимов дээрх илтгэлдээ “21-р зуунд дайн ба энх тайвны хоорондын зааг ялгаа улам бүр бүдгэрч байна. Дайныг урьдын адил зарлахаа больсон бөгөөд нэгэнт эхэлсэн бол бидний мэдэх уламжлалт арга хэлбэрээр явуулдаг цаг үе өнгөрчээ. “Өнгөт хувьсгал” хэмээн нэрлэгддэг Хойд Африк, Ойрх Дорнод гэх мэт газруудад өрнөж буй дотоодын бослого, тэмцэл хөдөлгөөн, цэргийн мөргөлдөөнүүд нь хөгжлийн хувьд хэнээс ч хараат бус улсууд хүртэл хэдхэн сар, өдрийн

<sup>1</sup> “Interdependence”

<sup>2</sup> “Hybrid Warfare” хэмээх ойлголтыг энэхүү судалгааны ажилд “гибрид дайн” хэмээх нэр томъёогоор тэмдэглэв.

<sup>3</sup> Доклад начальника ГШ ВС РФ В.Герасимова на общее собрание АВН. “Основные тенденции развития форм и способов применения ВС, актуальные задачи военной науки по их совершенствованию». <https://www.vpk-news.ru/articles/14632>

дотор гадны улсуудын халдлагад өртөн хатуу ширүүн дайн тулааны талбар болж, эмх замбараагүй байдал ноёрхон хүмүүнлэгийн гамшиг ба иргэний дайны хөлд нэрвэгдэж буйг харуулж байна.”<sup>4</sup> хэмээсэн. Тэрээр цааш нь илтгэлдээ “цэрэг батлан хамгаалах салбарын хүмүүсийн хувьд “Арабын хавар”-ын үйл явдал бол дайн биш, тиймээс цэргийнхэнд тэнд судлах зүйл байхгүй хэмээн орхиж болох л юм. Тэгвэл эсрэгээрээ яг энэ үйл явдлууд чинь 21-р зууны дайны өнгө төрхийг илтгэж буй юм биш биз?” хэмээн “Арабын хавар”-ын жишээн дээр орчин цагийн дайны хэлбэр, агуулгыг тодорхойлсон байна.

Иймээс олон улсын харилцааны өнөөгийн онцлог, нөхцөл байдал ба цаашдын чиг хандлагыг “гибрид

дайн”-ы учир шалтгаантай холбон тодорхойлох нь түүхэн цаг хугацааны хувьд төдийгүй, онолын судалгааны хувьд нэн шаардлагатай хэмээн үзсэн учир энэхүү судалгааны ажлыг хийсэн болно.

Ялангуяа өнөөгийн олон улсын харилцааны системийг шинээр тодорхойлохыг зорьж буй Хятад, Орос хэмээх хоёр томоохон гүрний дунд оршдог, геополитикийн хувьд энэ хоёр гүрэн болоод АНУ-ын ашиг сонирхол хүчтэй илэрч байдаг Монгол Улсын хувьд олон улсын харилцааны энэхүү шинэ ойлголтын талаар онол, практикийн үүднээс олон талаас нь судалж, учирч болох эрсдлийн үнэлгээг сайтар хийх нь зүйд нийцнэ.

### Үндсэн хэсэг

Олон улсын харилцаа болон цэргийн шинжлэх ухаанд сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд “гибрид дайн” хэмээх нэр томъёог түгээмэл ашиглах болсон. Ялангуяа 2014 оны хавар эхэлсэн Крымын асуудлын дараачаар барууны судлаачдын дунд ОХУ-ын нөлөөний хүрээгээ тэлэх бодлогын талаар судалгаа хийхдээ энэхүү гибрид хэмээн нэрийдээд байгаа дайны талаар судлах хандлага идэвхжсэн. Нөгөө талаас Оросын судлаачдын дунд ч энэ талын судалгааны ажил эрчимтэй хийгдэж байна. НАТО-гийн тэлэлт, Украин, Гүрж болон хуучин ЗХУ-ын нөлөөнд багтаж байсан улсуудыг Оросын

геополитикийн нөлөөллөөс гаргах гэсэн барууны улс төрчдийн үйл ажиллагааг энэхүү гибрид дайны арга ажиллагаатай холбон судлах судлаачдын тоо нэмэгдэж байна.

Өнөөдрийн байдлаар “гибрид дайн”-ы тухай нэгдсэн тодорхойлолт үгүй байна. Судлаачдын нийтлэг хандлагаар уламжлалт болон уламжлалт бус дайны арга хэрэгслүүдийг хослуулан ашиглаж, сөргөлдөгч талдаа цохилт өгөх зорилго бүхий цэрэг дайны стратегийг “гибрид дайн” хэмээн нэрлэж болох юм. Энэхүү “гибрид дайн” хэмээх нэр томъёог АНУ-ын ДеПол Их Сургуулийн түүхийн профессор

<sup>4</sup> Мөн тэнд.

Томас Моккайтис “Гибрид дайн: Индонезийн сөргөлдөөн”<sup>5</sup> хэмээх нэг сэдэвт бүтээлдээ анх удаа хэрэглэсэн байдаг. Харин 2006 онд тухайн үедээ АНУ-ын Тэнгисийн явган цэргийн Корпусын дэд хурандаа байсан Фрэнк Хоффман “уламжлалт бус цогц дайн”<sup>6</sup> гэсэн нэр томъёог ашиглан агуулгын хувьд өнөөдрийн бидний ойлгож буй ойлголтыг анх удаа утгын хувьд илэрхийлсэн бол 2007 онд хэвлүүлсэн нэгэн бүтээлдээ “гибрид дайн”-ы талаарх анхны тодорхойлолтыг гаргажээ. Тэр нь: “Гибрид дайн гэдэг нь ердийн дайны зэрэгцээ алан хядах ажиллагаа, ялгаварлан гадуурхалт, албадлага, эрүүгийн эмх замбараагүй байдал зэрэг олон янзын хэлбэрийг агуулдаг тогтсон бус бүтэц бүрэлдэхүүн, тактикийн аргуудыг ашиглан явуулж буй дайны хэлбэр”<sup>7</sup> хэмээх тодорхойлолт юм. Тэгвэл энэхүү тодорхойлолтыг Ф.Хоффман өөрөө болон бусад судлаачид дараа дараагийн судалгааны ажлууддаа шинээр тодорхойлох болсон.<sup>8</sup>

Дээр нэр дурдсан, одоогоор АНУ-ын Үндэсний Батлан Хамгаалах Их Сургуулийн Стратегийн Судалгааны Төвийн судлаачаар ажиллаж буй доктор Фрэнк Хоффман 2014 оны 7

сарын 28-нд гадаад бодлого, аюулгүй байдлын судалгааны чөлөөт платформ болох “War on the Rock” хэмээх вэб хуудсанд “Тийм ч шинэ бус дайн: Гибрид аюул занал ба улс төрийн дайн”<sup>9</sup> сэдэвт судалгааны ажлаа нийтлүүлсэн бөгөөд тэрээр Украинд өрнөж буй үйл явдал нь Барууны улсуудын дайны тухай ойлголтыг ихээхэн өөрчилж буй тухай бичжээ. Ялангуяа ОХУ-ын Зэвсэгт Хүчний Жанжин Штабын Ерөнхий Удирдлагын Газрын ажилтнуудын оролцоо, дэмжлэгтэй салан тусгаарлагчид, оросын хэт үндсэрхэг үзэлтнүүд, зэвсэгт тэмцэгчдийн зүгээс Украинаас салан тусгаарлах зорилгоор явуулж буй уламжлалт болон уламжлалт бус дайны ажиллагааг “улстөрийн дайн” ба “гибрид аюул занал” хэмээн нэрийдэн тодорхой жишээнүүдээр батлахыг зорьсон байна.

Лондонд төвтэй Стратегийн Судалгааны Олон Улсын Хүрээлэнгээс эрхлэн гаргасан “2015 оны зэвсэгт мөргөлдөөний судалгаа” хэмээх судалгааны бүтээлд хэвлэгдсэн анхаарал татах нэг ажил бол цэргийн түүх судлаач, АНУ-ын томоохон тинк-танк болох Гадаад Харилцааны Зөвлөлийн үндэсний аюулгүй байдлын

<sup>5</sup> Mockaitis, Thomas R. “A Hybrid War: The Indonesian Confrontation.” In *British Counterinsurgency in the Post-imperial Era*. Edited by Thomas R. Mockaitis, 14–44. Manchester, UK: Manchester University Press, 1995.

<sup>6</sup> Hoffman, Frank G. “Complex Irregular Warfare: The Next Revolution in Military Affairs.” *Orbis* 50.3 (2006): 395–411.

<sup>7</sup> Hoffman, Frank G. “Conflict in the 21st Century: The Rise of Hybrid Wars”. Arlington, VA: Potomac Institute for Policy Studies, 2007.

<sup>8</sup> <https://www.oxfordbibliographies.com/view/document/obo-9780199743292/obo-9780199743292-0260.xml#obo-9780199743292-0260-bibItem-0003>

<sup>9</sup> Frank Hoffman, “On Not-So-New Warfare: Political Warfare vs. Hybrid Threats,” War on the Rocks (blog), 28 July 2014, <http://warontherocks.com/2014/07/on-not-so-new-warfare-political-warfare-vs-hybrid-threat>

судлаач Макс Бүтийн “Мөргөлдөөний шинж чанарт гарч буй өөрчлөлт”<sup>10</sup> сэдэвт судалгааны ажил юм. Энэхүү судлаач “гибрид дайн” гэдэг нь сүүлийн зуун жилийн хугацаанд түгээмэл хэрэглэгдэж буй эртний улсуудын дайнаас улбаатай ойлголт бөгөөд дайсныхаа эсрэг уламжлалт болон уламжлалт бус арга хэрэгслийг хослуулан хэрэглэх тухай ойлголт юм” хэмээжээ. Мөн тэрээр гибрид дайны ул мөрийг сүүлийн 5000 жилийн хугацааны турш гарч байсан дайн мөргөлдөөнүүдээс олж харж болох тухай бичээд, эртний хот-улсууд бий бий болж, тэдгээр нь өөрийн гэсэн цэрэг армитай болсон үеэс “гибрид дайн” явуулах боломж бүрдсэн хэмээн үзжээ. Мөн түүхийн явцад Британичууд өөрийн колони улсуудад хяналтаа хадгалж үлдэхийн тулд янз бүрийн арга хэрэгслийг ашиглан тэмцэж буй колони орны ард иргэд, босогчдын эсрэг гибрид хэлбэрийн дайны арга барилыг сонгон хэрэглэж байсан тухай судалсан байна.

Лондонгийн Эзэн Хааны Коллежийн Батлан Хамгаалах Судлалын Тэнхимийн ахлах багш, доктор Род Торнтоны 2015 оны 9 сард хэвлүүлсэн “Орчин үеийн дайны өөрчлөгдөн буй хэв маяг: Оросын мэдээллийн дайнд өгөх хариулт”<sup>11</sup> сэдэвт өгүүлэл нь гибрид дайны тухай хийгдсэн бас нэг судалгааны ажил юм. Барууны улсуудын цэрэг, батлан хамгаалах салбарын өндөр албан тушаалтнууд “уламжлалт бус” дайны үр нөлөөг хүлээн зөвшөөрч буй хэдий

ч уламжлалт бус дайны олон арван арга хэрэгслийн талаар танин мэдэхийн сацуу өөрсдийн үйл ажиллагаандаа авч хэрэглэх ёстой талаар бичсэн. Жишээлбэл, мэдээллийн дайн нь Оросын НАТО-гийн эсрэг ашиглаж буй маш шилдэг арга. Ямар учир Оросууд Крымын асуудал дээр ялалт байгуулж чадсан талаар хийсэн өөрийн судалгааны дүгнэлтийг танилцуулсан байна. Тэрээр Оросын тал уламжлалт цэргийн ажиллагаа явуулахаас илүүтэй мэдээллийн кампанит ажлыг үр дүнтэй хийсэн нь ялалтад хүргэсэн хэмээжээ. Иймд барууны улсууд энэхүү уламжлалт бус арга хэрэгслийг өрсөлдөгчийнхөө эсрэг ашиглах нь үр дүнтэй хийгээд үүний тулд барууны улс орнуудын дундах олон улсын эрх зүйн зөрүүтэй ойлголтыг үгүй хийж үйл ажиллагаагаа нэгтгэх замаар зорилгодоо хүрч болно хэмээх зөвлөмжийг гаргажээ.

НАТО-гийн Европ дахь Холбоотны Дээд Командлал ба Германы Батлан Хамгаалах Штабын Зэвсэгт Хүчний асуудал эрхэлсэн дэд тэргүүн, ХБНГУ-ын БХЯ-ны Бодлого Төлөвлөлтийн Газрын судлаач асан Ральф Д.Тилегийн 2015 оны 5 сард нийтлүүлсэн “Украин дахь хямрал-Гибрид дайны үүсэл” сэдэвт судалгааны ажил нь энэ талаар хийсэн дорвитой судалгааны ажлуудын нэг мөн. Тэрээр “Гибрид дайн гэдэг нь уламжлалт болон уламжлалт бус, арга хэрэгслийн хослол. Тэдгээр нь ердийн цэргийн хүч болоод тусгай бэлтгэгдсэн тагнуулын ажилтнууд, улс төрийн өдөөн хатгагчид болоод

<sup>10</sup> Max Boot, “Countering Hybrid Warfare,” in *Armed Conflict Survey 2015*, ed. Nigel Inkster (London: IISS, 2015);

<sup>11</sup> Rod Thornton, “The Changing Nature of Modern Warfare,” *RUSI Journal* 160:4 (2015): 40–48

*хэвлэл мэдээллийнхэн, террорист бүлэг болон эрүүгийн гэмт хэрэгтнүүдийн оролцоотойгоор сэргэлдөгч талын дотоод улс төр, үзэл суртлын зөрчилдөөнийг тасралтгүй дэвэргэх, улс төрийн өдөөн хатгалт ба цахим халдлага хийх замаар хэрэгждэг”*<sup>12</sup> хэмээн гибрид дайныг тодорхойлсон байна. Мөн тэрбээр уламжлалт дайны арга хэрэгслүүд өнөөгийн олон улсын харилцаанд үр нөлөөтэй хэвээр байгаа хэдий ч 21-р зуунд өрнөх хямрал мөргөлдөөнд ялалтанд хүрэх гол арга нь биш хэмээн үзжээ. Гибрид дайны аюул занал бодитой болсон хийгээд аливаа улс үндэстний ирээдүйн аюулгүй байдлын асуудлыг тодорхойлох үндсэн нөхцөл нь ийм хэлбэрийн дайн болох тухай судалж дүгнэжээ.

Уламжлалт дайны ажиллагааг эхлүүлэх боломжгүй нөхцөл байдалд, аль эсвэл эхлүүлэхийн өмнө уламжлалт бус дайны арга хэрэгслүүдийг ашиглан сэргэлдөгч улсаа дотроос нь хагалган бутаргах, сулруулах нь гибрид дайны үндсэн арга юм. Ингэхдээ хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээг ашиглах, сонгуулийн үр дүнд нөлөөлөх, улс төрийн сөрөг хүчнийг дэмжих зэрэг олон төрлийн аргуудыг олон улсын харилцааны янз бүрийн оролцогчид ашиглаж байна. Тэгвэл судалгааны ажлынхаа дараах хэсэгт гибрид дайны ямар загварууд байдаг тухай, тэдгээр оролцогчид ямар арга хэрэгслийг хэрхэн ашигладаг тухай тоймлон гаргахыг оролдлоо.

Дээр нэр дурдсан Р.Тиле гибрид дайны хоёр загварыг судалгааныхаа

ажилдаа танилцуулсан байдаг. Түүний боловсруулсан нэг дэх загвар болох “Исламын Улс Бүлэглэлийн загвар” нь дараах бүтэцтэй байна:

- *Хосолсон тактикийн ажиллагаа:* Исламын Улс Бүлэглэлийн бүтцэд уламжлалт цэргийн анги нэгжүүд, жижиг хагас бие даасан бүлгүүд багтах ба уламжлалт болон партизаны ажиллагааг явуулах;
- *Уян хатан, дасан зохицох бүтэц:* Исламын Улс Бүлэглэл нь шинээр элсэгчид, шинэ зэвсэглэл, шинэ газар нутаг зэрэг шинэ нөөц боломжийг хурдан өөриймшүүлэх тактикийг баримтлах;
- *Терроризмын үйл ажиллагаа:* Исламын Улс Бүлэглэл нь дэлхий даяар террорист халдлага үйлдэх, “буруу номтон”-уудын амь насыг хороож буй бичлэгийг нийгмийн сүлжээ ашиглан дэлхий даяар тархах;
- *Суртал ухуулга ба мэдээллийн дайн:* “Жиргээ”, видео, блог зэргээр дамжуулан Исламын Улс Бүлэглэлийн үйл ажиллагааг сурталчлах;
- *Гэмт хэргийн үйл ажиллагаа:* Газрын тос, улаан буудай, эртний үнэт зүйлс зэргийг хар зах дээр борлуулах зэрэг хууль бус наймаа эрхлэх;
- *Олон улсын эрх зүйн хэм хэмжээг үл хайхрах:* Хүмүүнлэгийн болон эрх зүйн хэмжээг үл хүндэтгэх,

<sup>12</sup> Ralph D. Thiele, “Crisis in Ukraine – The Emergence of Hybrid Warfare,” ISPSW Strategy Series, May 2015.

Шариатын хуулийн хэм хэмжээг түгээн дэлгэрүүлэх, зөрчсөн этгээдийг олон нийтийн өмнө гэгсгээн шийтгэх зэрэг болно<sup>13</sup>

ОХУ-ын Цэргийн Шинжлэх Ухааны Академийн гишүүн, Цэргийн Дипломатуудын Холбооны шинжээч Александр Бартош 2022 оны 2-р сарын 24-нд “Независимое Военное Обозрение” сонинд хэвлүүлсэн “АНУ болон НАТО-гийн дэлхийн гибрид дайны стратеги”<sup>14</sup> хэмээх өгүүлэлдээ барууны орнуудын, тухайлбал АНУ-ын Оросын эсрэг хэрэгжүүлж буй гибрид дайны талаар судалсан байна.

Александр Бартош АНУ болон НАТО-гийн улсуудын ОХУ-тай харилцах бодлого нь “Хэт их ачаалалтай, тэнцвэргүй Орос. Өртөг тооцох сонголтуудын нөлөөллийг үнэлэх”<sup>15</sup> гарчиг бүхий “RAND Corporation”-оос 2019 онд гаргасан суурь судалгааны зөвлөмж бүхий тайланд дурдсан стратегиар хэрэгжиж буйг онцолжээ. Тэрхүү стратеги нь Оросын улс төр, эдийн засгийн системийг тогтворгүй болгон нийт ард иргэдийнх нь сэтгэл санааг өөрчлөх замаар шийдвэр гаргагч дээд элит хэсгийн барууны эсрэг сэтгэл зүйг өөрчлөн улмаар Оросыг бүхэлд нь барууны өмнө толгой гудайлгах аж. Үүний тулд Оросын нөлөөнд оршиж буй эмзэг газруудад хямралт байдал үүсгэх тактикийг ашиглах

бөгөөд үүний тулд гибрид дайны тодорхой аргуудыг ашиглах хэмээжээ. Тэрхүү тайланг харвал, тодорхой бүс нутгуудыг онцолсны зэрэгцээ зарим нэг арга тактикийг санал болгожээ. Тэдгээр эмзэг гэгдэж буй бүс нутгуудад хэрэгжүүлэх АНУ-ын тодорхой зорилтууд нь:

- Украинд зэр зэвсгийн тусламж үзүүлэх;
- Сирийн босогчдод үзүүлж буй тусламжийг нэмэгдүүлэх;
- Беларусийн либерал талын хөдөлгөөнийг дэмжих;
- Өмнөд Кавказтай харилцаагаа өргөтгөх;
- Төв Ази дахь Оросын нөлөөг бууруулах;
- Приднеостровын бүс нутгаас Оросын цэргийг шахан гарах зэргээр хэрэгжих бол гибрид дайны тодорхой аргуудыг мөн дурдсан байна.

Чингэхдээ үзэл суртлын болон мэдээллийн зардлыг өсгөх замаар хэрэгжүүлэх ажээ. АНУ-ын хэрэгжүүлэх ёстой тэдгээр аргууд нь:

- Оросын сонгуулийн системд үл итгэх хандлагыг олон нийтийн дунд нэмэгдүүлэх;
- Ард олны ашиг сонирхлыг хангаж чадахгүй дэглэм тогтож буй гэдгийг сурталчлан итгүүлэх;
- Оросын дотоод дахь идэвхтэй болон хүч үл хэрэглэх

<sup>13</sup> Мөн тэнд.

<sup>14</sup> Александр Бартош. “Мировая гибридная война в стратегии США и НАТО”. “Независимое Военное Обозрение”. 24.02.2022

<sup>15</sup> James Dobbins, Raphael S. Cohen, Nathan Chandler, Bryan Frederick, Edward Geist, Paul DeLuca, Forrest E. Morgan, Howard J. Shatz, Brent Williams. “Overextending and Unbalancing Russia. Assessing the Impact of Cost, Imposing Options” RAND Corporation. 2019. [https://www.rand.org/pubs/research\\_briefs/RB10014.html](https://www.rand.org/pubs/research_briefs/RB10014.html)

эсэргүүцлийн хөдөлгөөнүүдийг дэмжих;

- Гадаад дахь Оросын имиж, нэр хүндийг унагах зэрэг байна.

Эдгээр уламжлалт бус аргуудын зэрэгцээ уламжлалт дайны арга хэрэгслүүдийг Оросын эсрэг ашиглах зөвлөмжийг мөн боловсруулсан байна. Уламжлалт дайны арга хэрэгслийг түлхүү ашиглахыг АНУ-ын шийдвэр гаргагчдад санал болгосон болохыг энэхүү тайлангаас харж болно.

АНУ-ын армийн офицер Алекс Дийп “Small Wars Journal”-д хэвлүүлсэн өгүүлэлдээ “Уламжлалт дайны арга тактик, уламжлалт бус арга хэрэгслүүд, террорист халдлага зэргийг нэгэн зэрэг хослуулсан орчин үеийн гибрид дайн нь аль ч үед ашиглаж болох олон талт цэргийн ажиллагаа юм. Ирак, Афганистан дахь дайны дараа АНУ-ын зүгээс зэвсэгт тэмцэгчдийн эсрэг цэргийн ажиллагаанд улам бүр анхаарлаа хандуулах болсон. Гэсэн хэдий ч зөвхөн босогчид болоод зэвсэгт тэмцэгчид нь АНУ-ын цэрэг армийн цор ганц сорилт биш юм”<sup>16</sup> гэжээ. Үүнээс харахад АНУ-ын тал ч энэхүү “гибрид дайн”-ы тактикт анхаарч буйг харж болно.

“АНУ болон дэлхийн бусад гүрнүүд “хүйтэн дайн”-ы дараах үеийн дайн болох зэвсэгт босогчдын дайнд төдийлөн анхаараагүй нь стратегийн хувьд томоохон алдаанд

хүргэсэн. Орчин үеийн “гибрид дайн”-д оролцож буй цэргийн командлагч нь уламжлалт, өндөр эрчимт цэрэг дайны анги нэгтгэлийг төвлөрсөн бус тусгай цэргийн хүч, өндөр технологийн платформ дээр суурилсан мэдээллийн нарийн төвөгтэй ажиллагаатай хослуулан ашиглах чадвартай байх шаардлага бий болж байна. Гибрид дайны тухай ойлголт нь шинэ зүйл биш боловч арга хэрэгсэл нь улам боловсронгуй болж, үхэлд хүргэх тул хариу арга хэмжээ авахыг шаардаж байна”<sup>17</sup> хэмээн Алекс Дийп өөрийн өгүүлэлдээ АНУ-ын батлан хамгаалахын салбарынханд анхааруулан бичсэн байна.

Барууны судлаачид Оросын гибрид дайны арга тактикийн талаар нэлээд тооны судалгаа хийснээс өмнө нь нэр дурдсан судлаач Р.Тилегийн нэр бүхий бүтээлд “Оросын загвар” гэгчийг танилцуулсан бөгөөд энэ загвар нь дараах аргуудаар хэрэгжих ажээ. Тэдгээр нь:

- Сөргөлдөгч улсын дотоод хямрал, тэмцлийг өдөөн дэвэргэх замаар тогтворгүй байдал үүсгэх;
- Эдийн засаг болон дэд бүтцийг нь сүйрүүлэх замаар улсыг дотроос нь задлан бутаргах;
- Тухайн улсын улс төрийн шийдвэр гаргагчдыг өөрсдийн тусгай бэлтгэгдсэн агентуудаар солих зэрэг ажээ.

<sup>16</sup> Alex Deep. “Hybrid War: Old Concepts, New Techniques”. Small Wars Journal. 03/02/2015 <https://smallwarsjournal.com/jrnl/art/hybrid-war-old-concept-new-techniques>

<sup>17</sup> Мөн тэнд.



ОХУ-ын “гибрид дайн”-ы номлолын эдгээр арга тактик нь дараах байдлаар хийгдэх ажээ. Эдгээр нь:

- Европын эдийн засгийн гол салбаруудад хөрөнгө оруулалт хийх,
- Ийнхүү хөрөнгө оруулалт хийхдээ Европын улс төр, эдийн засгийн элит хэсэгт хээл хахууль өгөх замаар хийх,
- Хэвлэл мэдээллийн нэгжүүдийг худалдан авах, Оросын талыг баримтлагчдын болон интеграцчлалын эсрэг үйл ажиллагааг дэмжих,
- Цэрэг батлан хамгаалах бодлогын шийдвэр гаргахад нөлөөлөх зорилгоор зэвсгийн наймаа хийх,
- Европын Холбооны салбар байгууллагуудад өргөн цар хүрээтэй тагнуулын нэвтрэлт хийх,
- Оросын зохион байгуулалттай гэмт хэрэг ба орон нутгийн эрүүгийн бүрэлдэхүүн хэсгүүдийн хоорондын холбоог бэхжүүлэх,
- Шашны байгууллагуудын хооронд хэлхээ холбоо тогтоох, шийдэгдээгүй угсаатны зөрчлийн хурцадмал байдлыг ашиглах, “цөөнхийн эрх” -ийн төлөөх кампанит ажил зохион байгуулах,
- Гадаадад байгаа Оросын хэвлэл мэдээллийн нэгжүүдэд

томоохон хэмжээний дэмжлэг үзүүлэх,

- Сонгож авсан байнууддаа томоохон зохицуулалт бүхий кибер халдлагуудыг хийх<sup>18</sup> зэрэг арга тактикийг ашиглах ажээ.

Тэгээд эцэст нь Москвагийн зүгээс энэхүү гибрид дайны арга хэрэгсэлдээ тулгуурлан зорилгодоо хүрч буйг дурдаад энэ хандлага нь Азийн геополитикийн орон зайд ч идэвхжиж буйг сануулан үүний эсрэг Европ болон Азийн тодорхой улсууд хамтын хүчээр хариу арга хэмжээ авах хэрэгтэй хэмээх зөвлөмжийг гаргасан байна.

Украины БХЯ-ны “сайн дурын десант”-ын оролцогч, украин болон орос хэл дээр хэвлэгдсэн “Гибрид дайны шастир” номын зохиогч О.А.Карпюк *“Гибрид дайны үеийн хаос байдлын онол (Герасимовын номлол)”*<sup>19</sup> хэмээх өгүүлэлдээ Оросын “гибрид дайн”-ы үндсэн зорилго нь АНУ бөгөөд Америкийг өөрсдийн гол өрсөлдөгчөө хэмээн тооцож буй талаар бичжээ. Тэрээр *“ОХУ нь АНУ-тай цэрэг стратегийн хувьд ч тэр, эдийн засгийн асуудлаар ч тэр, технологийн хувьд ч тэр өрсөлдөх боломжоор тун хомс. Иймд тулалдааны шинэ талбарыг сонгож байгаа бөгөөд энэхүү “дайн”-ы үр дүнд АНУ-аас илүү хүчирхэг болох бус харин өрсөлдөгчөө өөрийнхөө*

<sup>18</sup> Ralph D. Thiele, “Crisis in Ukraine – The Emergence of Hybrid Warfare,” ISPSW Strategy Series, May 2015.

<sup>19</sup> Карпюк.О.А. (Серж Марко). Теория хаоса в гибридной войне (Доктрина Герасимова). Петр и Мазепа. <https://petrimazepa.com/chaostheory.html>

түвшинд авчрахыг зорьж байна”<sup>20</sup> хэмээжээ. Оросын талаас АНУ-ын сонгуулийн системд хакердах замаар нэвтэрч үр дүнг нь өөрчилсөн байх магадлал тун бага. Харин нийгмийн сүлжээгээр дамжуулан буруу ташаа мэдээлэл түгээх, АНУ дахь зарим нэг улс төр, эдийн засгийн бүлэглэлүүдтэй хуйвалдах замаар Америкийг дотроос нь хагалган бутаргах ажлыг зохион байгуулсан байх магадлал өндөр ажээ. В.Герасимов илтгэлдээ “Мэдээллийн салбар дахь сөргөлдөөн нь бидэнд дайсны цэрэг батлан хамгаалах чадварыг бууруулахад ихээхэн боломж олгоно”<sup>21</sup> гэснээс харахад Оросууд энэ аргыг Америкт ашигласан байх боломжтой талаар уг судлаач өгүүлэлдээ дурджээ. Оросын гадаад бодлого болон аюулгүй байдлын талаар судалгаа хийдэг судлаачдын зарим нь Герасимовын дээрх илтгэлийг шинэ зүйл огт биш, энэ арга тактикийг Оросууд өмнө нь ч ашиглаж байсан талаар бичдэг. Гэхдээ Оросын талаас явуулж буй энэхүү “гибрид дайн”-ы бодлого нь олон түвшинд, системтэйгээр үйлдэгдэж байгаа нь олон жишээн дээр батлагддаг. Францын ерөнхийлөгчийн сонгуулийн өмнө Засгийн газраас Оросын мэдээллийн ажиллагааг анхааруулж байсан явдал нь үүний тод илрэл юм.

Оросын эрдэмтэн, эдийн засгийн ухааны доктор В.Катасонов “Радио Аврора”-д өгсөн ярилцлагадаа: “Өнөөдөр Дэлхийн 2-р дайны

дараачаар эхэлж 1991 онд дууссан “хүйтэн дайн”-аас ч өргөн хэмжээний дайн өрнөж байна. Орчин үеийн энэ дайныг бид “гибрид дайн” хэмээн нэрлэдэг. Дайны ажиллагаа цоо шинэ түвшинд гарч, өөр хэлбэрт шилжсэн. Энэ дайнд бид уламжлалт аргуудыг ч харна, тагнуулын тусгай албадын оролцоог ч олж харна, Дээр нь сэтгэлзүйн дайн, мэдээллийн дайн, эдийн засгийн дайн гэх мэтчилэн олон хэлбэрээр бүх түвшинд зэрэг явагдаж байна. Энд мэдээж мөнгө-санхүүгийн гүйцэтгэх үүрэг улам нэмэгдсээр байгаа юм гэдгийг дахин давтан хэлье”<sup>22</sup>

2016 оны НАТО-гийн Варшавын Дээд хэмжээний уулзалтаар “гибрид дайн”-ы асуудлыг уулзалтад оролцогчид идэвхтэй хэлэлцсэн төдийгүй Оросын явуулж буй гибрид дайны бодлогыг сэргүүлэх стратегийг боловсруулах тал дээр тохиролцсон байдаг. Харин АНУ нь батлан хамгаалах бодлогын түвшинд гибрид дайны талаар нэгдсэн нэг ойлголт хүрээгүй бөгөөд энэ асуудалд олон өнцгөөс хандаж буй тухай Америкийн цэрэг батлан хамгаалахын асуудлыг судалдаг судлаачид дүгнэсэн байдаг. “2014 оны 9 сард гарсан АНУ-ын Үндэсний Батлан Хамгаалах бодлогын “цагаан ном”-нд уламжлалт бус дайны ажиллагааны үед хэрэгжүүлэх арга хэмжээнүүд анхаарал татаж байна. Үүнд Крымийн асуудлыг цэвэр гибрид дайны өнцгөөс

<sup>20</sup> Мөн тэнд.

<sup>21</sup> Доклад начальника ГШ ВС РФ В.Герасимова на общее собрание АВН. “Основные тенденции развития форм и способов применения ВС, актуальные задачи военной науки по их совершенствованию”. <https://www.vpk-news.ru/articles/14632>

<sup>22</sup> “Радио Аврора”. Интервью с экономистом Валентином Катасоновым. <https://www.youtube.com/watch?v=6b3DZfMUwRw>

тодорхойлсон ба америкийн талын үзэж байгаагаар Оросын Крымд явуулсан бодлого нь “Хамас” болон “Хезболла” бүлэглэлийг өөрийн зорилгодоо нийцүүлэн ашигласан Ираны туршлага ба 1990-ээд оны үед Хятадын талаас хэрэгжүүлж байсан “хил хязгааргүй дайн”-ы номлолын хосолсон хувилбар хэмээн дүгнэсэн” талаар Оросын судлаачид болох В.Коньшев, Р.Парфенов нар Оросын ОУХ-ны нэр хүндтэй сэтгүүл болох “Мировая экономика и международные отношения” сэтгүүлд нийтлэгдсэн өгүүлэлдээ бичжээ.<sup>23</sup>

Монгол Улсын Аюулгүй Байдал Судлалын Хүрээлэнгийн “Нийгэм-улс төрийн сөргөлдөөн ба хямралт нөхцөл байдал үүсэхэд нөлөөлөх шалтгаан, хүчин зүйл” хэмээх нийтлэлд “Олон улсын харилцааны өрнөлөөс харахад, дэлхийн хүчирхэг улс орнууд өөрсдийн ашиг сонирхлыг татаж буй улс оронд хямралт нөхцөл байдал үүсгэн, эрхшээлдээ оруулж, өөрийн нөлөө ашиг сонирхлоо бий болгохын тулд геостратегийн элдэв аргачлалыг ашигласаар ирсэн. Тухайлбал:

- “Өөрсдөөр нь өөрсдийг нь захируулах бодлого” буюу тэдний аливаа бодлогыг “сохроор дэмжигч” улс төрийн бүлэглэлийг тухайн улс оронд бий болгох, тэднийг төр засгийн өндөрлөгт шургуулах, тэднээр дамжуулан улс төрийн нөлөөллөө тогтоох.
- Материаллаг сонирхлыг нийгэмд дэвэргэх, ард түмэн,

байгалийн баялаг болон үнэт зүйлсээ худалдах урвагчийн сэтгэлзүйг бий болгох.

- Ардчиллын үнэт зүйлсийг гуйвуулан сурталчлах, улс үндэстний тархи угаалт зэргийг дурдаж болохоор байна”<sup>24</sup> хэмээжээ.

Дээрх бүгдээс “Гибрид дайн” хэмээх ойлголтыг дотор нь задалж үзвэл энэ нь “Уламжлалт” болон “Уламжлалт бус” дайны арга хэрэгслүүд цөм багтах бөгөөд **уламжлалт буюу сонгодог дайны ажиллагаанд:**

- Стратегийн тогтоон барих цэргийн арга хэмжээ авах,
- Стратегийн байршуулалт хийх,
- Байлдааны ажиллагаа явуулах,
- Энхийг сахиулах үйл ажиллагаа явуулах

зэрэг багтах бол **“уламжлалт бус” дайны арга ажиллагаанд:**

- Сөргөлдөгч улсын эсрэг эвсэл, холбоо байгуулах,
- Улс төрийн болон дипломат шахалт үзүүлэх,
- Эдийн засгийн хориг арга хэмжээ авах,
- Кибер халдлага үйлдэх, мэдээллийн төөрөгдөлд оруулах,
- Янз бүрийн асуудлаар нийгмийг хагарган бутаргах,
- Дотоод бослого тэмцэл, зөрчилдөөнийг дэвэргэх, (“*өнгөт хувьсгалууд*”)
- Сонгуулийн үр дүнд нөлөөлөх (*хэвлэл мэдээллийн хэрэгслээр*

<sup>23</sup> В.Коньшев, Р.Парфенов. “Гибридные войны: между мифом и реальностью” МИРОВАЯ ЭКОНОМИКА И МЕЖДУНАРОДНЫЕ ОТНОШЕНИЯ, 2019, том 63, № 12, с. 56-66

<sup>24</sup> <https://niss.gov.mn/archives/1546>

*болон нийгмийн сүлжээгээр дамжуулан хийх эсвэл кибер халдлага үйлдэх замаар)*

- Дипломат харилцаагаа таслах,
- Улс төрийн сөрөг хүчинг бий болгоход оролцох,
- Сөрөг хүчний хүчний үйл ажиллагааг дэмжих,
- Сөргөлдөгч орны эдийн засгийг дайны зардалд шилжүүлэх,
- Эдийн засгийн тогтворгүй байдал үүсгэхэд нөлөөлөх,
- Улс төрийн удирдлагад өөрсдийн талын хүчнийг гаргах зэрэг цогц арга хэмжээг хэрэгжүүлэх зэргийг багтааж болно.

Монгол Улсын хувьд ч гадны гибрид дайны арга хэрэгсэлд өртдөг болох нь өнөөдрийн нийгэмд өрнөж буй олон дуулиант асуудлаас харж болно. Орос-Украины дайнаас улбаалан манай улсын нийгмийн

сүлжээнд ч тодорхой байр суурийн зөрчлүүд гарч байна. Ингэснээр нийгэм талцах, хоёр хуваагдах, улмаар хагаралд хүрч байгаа жишээг “No War” хөдөлгөөн болон тэдний эсрэг байр суурийг илэрхийлж буй залуусын үйл ажиллагаануудаас харж болно. Кибер аюулгүй байдлын хүрээнд ч тодорхой асуудлууд байсаар байна. 2021 онд Монгол Улсад Хятадын 750 гаруй кибер халдлагын мэргэжилтнүүд нууцаар байрлаж үйл ажиллагаа явуулж байсан нь илэрсэн ноцтой хэрэг гарч байсан нь нэг том жишээ болсон. 2021 оны 11 сард Монголбанкны цахим хуудас гадны халдлагад өртөн нэвтрэх боломжгүй болж байв. Мөн сард Raidforums.com хэмээх гадны нэгэн сайт дээр нэгэн хакер Монгол Улсын 2.3 сая иргэний дэлгэрэнгүй мэдээлэл бүхий санг зарахаар байршуулсан зэргээс харахад манай улсын хувьд гадны цахим халдлагад ихээр өртдөг болох нь харагдаж байна.

## Дүгнэлт

Дүгнэхэд, олон улсын харилцаанд эрх мэдэл, нөлөөгөө тогтоохын төлөөх өрсөлдөөн нь гибрид дайны хэлбэрээр өрнөөд удаж буй бөгөөд энэхүү ойлголт нь олон улсын харилцааны судалгааны нэг чухал сэдэв болоод байна. Хэдийгээр зарим судлаачид “гибрид дайн” хэмээх ойлголтыг үгүйсгэж, энэ нь бодит зүйл биш, хэрвээ байх аваас энэхүү арга ажиллагаа нь өмнө нь ч хийгдэж байсан технологи гэж үздэг ч өнөөгийн олон улсын харилцаанд сөргөлдөж буй улс орнууд энэхүү “гибрид дайн”-ы аргуудыг хослуулан ашиглаж байгаа нь тодорхой юм.

Иймээс ч улс орнууд өөрсдийн гадаад, дотоод аюулгүй байдлын судалгаандаа энэхүү ойлголтын талаар нарийн судалгаа хийдэг болж, судлаачид энэ талын олон арван судалгааны бүтээлүүдийг хэвлүүлээд байна.

Гибрид дайн хэмээх ойлголт нь нэр томъёоны хувьд шинэ хэдий ч улс орнууд өөрсдийн гадаад бодлогоо амжилттай хэрэгжүүлэх, аюулгүй байдлаа баталгаажуулах, улмаар геополитикийн нөлөөний хүрээгээ тэлэх стратегид өнгөрсөн түүхийн туршид хэрэгжүүлж ирсэн болохыг олон улсын харилцааны

түүхийн тодорхой жишээнүүдээр батлагдаж байна. Германы цэргийн түүхч К.Клаузевиц “Дайны тухай” хэмээх алдарт бүтээлд *“Бүх цаг үе өөрийн гэсэн дайн байлдаантай, хязгаарлагдмал нөхцөлтэй, өөрийн гэсэн өвөрмөц урьдчилсан таамаглалтай байдаг”* гэснээс харахад дайн болгон тогтсон загвар, ойлголтоор хязгаалагдахгүй бөгөөд дайн бүрд тусад нь тохирсон стратегийг бэлтгэх ёстой ажээ.

Дээрх судалгааны үр дүнгээс харахад гибрид дайны арга хэрэгслүүдийг олон улсын харилцааны улс оролцогчдын зэрэгцээ Исламын Улс Бүлэглэл, Хамас, Хезболлах зэрэг улс бус тоглогчид ч ашигладаг байна. Мэдээж хэрэг олон улсын харилцааны голлох тоглогчид болох их гүрнүүд гибрид дайны арга хэрэгслүүдийг ашиглах нь түгээмэл. Орос-Украины дайнаас үүдэлтэйгээр АНУ ч тэр ОХУ ч тэр гибрид дайны арга тактикийг өөрсдийнхөө стратегид тохируулан ашиглахыг урьтал болгож байгаа нь ажиглагдлаа. АНУ-ын томоохон тинк-танк болох “RAND Corporation”-ы тайланг задлан шинжилбэл Оросын эсрэг ашиглах АНУ-ын гибрид дайны арга хэрэгсэлд “уламжлалт дайн”-ы

аргууд давамгайлж байна. Харин “Оросын загвар” гэгчийг томъёолсон судлаач Р.Тилегийн зөвлөмжөөс харвал Оросын гибрид дайны аргуудад “уламжлалт бус дайн”-ы аргуудыг түлхүү хэрэглэхээр тусгажээ.

Эцэст нь нэгтгэн дүгнэвээс, гибрид дайн хэмээх ойлголт нь олон улсын харилцааны оролцогчдын гадаад бодлогоо хэрэгжүүлэх нэг чухал хэрэглүүр болсон төдийгүй оролцогч бүр өөрсдийн нөөц бололцоо, хүч чадавхад тохируулан төрөл бүрийн аргуудыг ашиглан хэрэгжүүлж байна. Их гүрнүүдийн сөргөлдөөн, гибрид дайн өрнөж буй нөхцөлд үндэсний аюулгүй байдлаа сахин хамгаалахад “гибрид дайн”-ы хүчин зүйлийг сайтар тооцох нь Монгол Улсын хувьд чухал. Бусад улсын зүгээс ирж болох аюул заналыг урьдчилан таамаглах, сөрөн зогсоход “гибрид” тактикийг тооцоолж өөрийн аюулгүй байдлын эрсдлийн арга хэмжээг нарийн төлөвлөн, зөв зохион байгуулалттайгаар авах нэн шаардлагатай. Энэ тал дээр Монгол Улсын аюулгүй байдлын системд багтдаг байгууллага, шийдвэр гаргагчид төдийгүй хувь хүмүүс ч анхаарч байх зайлшгүй нөхцөл байдал бий болжээ.

## Ном зүй

### Ном, эрдэм шинжилгээний өгүүлэл:

*Англи хэл дээр:*

1. Clausewitz, Carl von. On War. Edited by Michael Howard and Peter Paret. Princeton, NJ: Princeton University Press, 1989.
2. Hoffman, Frank G. “Conflict in the 21st Century: The Rise of Hybrid Wars”. Arlington, VA: Potomac Institute for Policy Studies, 2007.
3. Hoffman, Frank G. “Complex Irregular Warfare: The Next Revolution in Military Affairs.” Orbis 50.3 (2006)
4. Max Boot, “Countering Hybrid Warfare,” in Armed Conflict Survey 2015, ed. Nigel Inkster (London: IISS, 2015)
5. Mockaitis, Thomas R. “A Hybrid War: The Indonesian Confrontation.” In British Counterinsurgency in the Post-imperial Era. Edited by Thomas R. Mockaitis, Manchester, UK: Manchester University Press, 1995.
6. Ralph D. Thiele, “Crisis in Ukraine – The Emergence of Hybrid Warfare,” ISPSW Strategy Series, May 2015.
7. Rod Thornton, “The Changing Nature of Modern Warfare,” RUSI Journal 160:4 (2015)

*Орос хэл дээр:*

1. В. Конышев, Р. Парфенов. “Гибридные войны: между мифом и реальностью” МИРОВАЯ ЭКОНОМИКА И МЕЖДУНАРОДНЫЕ ОТНОШЕНИЯ, 2019, том 63, № 12, с. 56-66

### Цахим эх сурвалж:

1. Alex Deerp. “Hybrid War: Old Concepts, New Techniques”. Small Wars Journal. 03/02/2015 <https://smallwarsjournal.com/jrnl/art/hybrid-war-old-concept-new-techniques>
2. Hoffman Frank G. “On Not-So-New Warfare: Political Warfare vs. Hybrid Threats,” War on the Rocks (blog), 28 July 2014, <http://warontherocks.com/2014/07/on-not-so-new-warfare-political-warfare-vs-hybrid-threat>
3. James Dobbins, Raphael S. Cohen, Nathan Chandler, Bryan Frederick, Edward Geist, Paul DeLuca, Forrest E. Morgan, Howard J. Shatz, Brent Williams. “Overextending and Unbalancing Russia. Assessing the Impact of Cost, Imposing Options” RAND Corporation. 2019. [https://www.rand.org/pubs/research\\_briefs/RB10014.html](https://www.rand.org/pubs/research_briefs/RB10014.html)
4. <https://www.oxfordbibliographies.com/view/document/obo-9780199743292/obo-9780199743292-0260.xml#obo-9780199743292-0260-bibItem-0003>
5. Аюулгүй Байдал Судлалын Хүрээлэн. “Нийгэм-улс төрийн сөргөлдөөн ба хямралт нөхцөл байдал үүсэхэд нөлөөлөх шалтгаан, хүчин зүйл. <https://>

niss.gov.mn/archives/1546

6. Александр Бартош. “Мировая гибридная война в стратегии США и НАТО”. “Независимое Военное Обозрение”. 24.02.2022. [https://nvo.ng.ru/concepts/2022-02-24/1\\_1178\\_strategy.html](https://nvo.ng.ru/concepts/2022-02-24/1_1178_strategy.html)
7. Доклад начальника ГШ ВС РФ В.Герасимова на общее собрание АВН. “Основные тенденции развития форм и способов применения ВС, актуальные задачи военной науки по их совершенствованию». <https://www.vpk-news.ru/articles/14632>
8. Карпюк.О.А. (Серж Марко). Теория хаоса в гибридной войне (Доктрина Герасимова). Петр и Мазепа. <https://petrimazepa.com/chaostheory.html>
9. “Радио Аврора”. Интервью с экономистом Валентином Катасоновым. <https://www.youtube.com/watch?v=6b3DZfMUwRw>

## Research and Evaluation of Contemporary International Relations and “Hybrid Warfare”

*Myagmardorj Purevdorj*

*Ph.D*

*Department of International Relations and Social Studies,  
University of the Humanities, Ulaanbaatar, Mongolia  
myagmardorj@humanities.mn*

**Abstract:** *The main purpose of this paper is to conduct qualitative research based on the research work of some foreign and domestic researchers who studied the concept of “hybrid war” in modern international relations and the nature, form and tactics of “hybrid war”. This study was conducted because it was deemed necessary to do some research on the risks of external factors that could negatively affect Mongolia’s national security in the context of the unstable international relations stemming from the current international relations and confrontations of great powers. After the Crimean crisis that started in the spring of 2014, the term “hybrid war” began to be commonly used among Western researchers to study Russia’s policy of expanding its sphere of influence, especially its geopolitical policy toward Ukraine. The combination of “conventional” and “non-conventional” war methods, which are carried out in order to divide Ukraine from within and support separatist activities, have been studied in the context of “hybrid war”. However, this research work shows that this “hybrid war” has many different models and manifests itself in many forms due to many factors such as the military force, economical capability, political power and geographical location of the opposing countries.*

**Keywords:** *Gerasimov doctrine, hybrid warfare, methods of hybrid warfare*

<i>The day of submission:</i>	<i>2022.12.19</i>
<i>Completion of review:</i>	<i>2023.04.28</i>
<i>Final decision for acceptance:</i>	<i>2023.05.04</i>